

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Цэгц богд төв аудит ХХК-ийн Аудитор: П.Пунцаг

Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 92

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2468 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох зардалд 536,702.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 28,666.8 мянган төгрөгийн санхүүжилт тус тус авсан байна. Эрүүл мэндийн газраас 27,110.8 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, аж ахуй, хангамжийн материал үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 66 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 5 арга хэмжээг бүрэн, 61 арга хэмжээг 90.0-99.0 хувиар нийт дүнгээр 97.5 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 93.5 хувиар, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 74.5 хувиар үнэлэгдсэн байна.

07020152

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Дэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Эргэлтийн хөрөнгийн дүн	69,592.2	80,994.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	358,806.1	313,338.9
Нийт хөрөнгийн дүн	428,398.3	394,333.6
Нийт өр төлбөрийн дүн	372.2	22,221.9
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	428,026.2	372,111.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	428,398.3	394,333.6
Үйл ажиллагааны орлогын дүн	9,620,155.1	5,763,042.2
Үйл ажиллагааны зардлын дүн	6,939,962.2	6,322,186.3
Үйл ажиллагааны үр дүн	2,680,193.0	(559,144.1)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	2,680,193.0	(559,144.1)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,298.5	428,026.2
Тайлант оны үр дүн	267,727.6	(55,914.4)
Эцсийн үлдэгдэл	428,026.2	372,111.8
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	726,098.8	523,233.2
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	670,402.7	527,964.7
Үйл ажиллагааны ЦМГ	55,696.1	(4,731.5)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(50,525.5)	(439.1)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5,170.7	(5,170.6)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,170.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,170.7	0.1
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		528,064.5
Урсгал зардал		527,625.4
Хөрөнгийн зардал		439.1
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		528,064.5
Эрүүл мэндийн даатгалын сангаас		494,566.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих		28,327.5
Урьд оны үлдэгдлээс		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Залруулагдаагүй нийт 9.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9.8 сая төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 9.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин түлш халаалтын зардлаас 0.1 сая төгрөгийн материал бэлтгэсэн нь Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эм боох материал 9.7 сая төгрөгийг аж ахуйн материалд орлого авч, зарлага гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

3. Эмийн үлдэгдэлд хугацаа дууссан 11 нэр төрлийн 12.7 сая төгрөгийн эм байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Дэлгэр сумын Эрүүл мэндийн төв	3	9.8	-	-	3	9.8	-	-	-	-	-
Дүн	3	9.8	-	-	3	9.8	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөл тгүй	Хязгаар лалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруул сан	Аудит хийгээгү й				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			